



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/803

Ховд

Зөвлөх баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 а, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор ажлын тоо, хэмжээ боловсруулах, зураг төслийг хянах, барилга, байгууламжийн норм, норматив, стандартыг хангуулах, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хяналт хийх зөвлөх багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Төсөл арга хэмжээний ажлын тоо хэмжээ, зураг төсөлийг хянаж, ажлын гүйцэтгэл явцын хяналт хийж гарсан зөрчлийг тухай бүр арилгуулж, ашиг сонирхлоос ангид байж захиалагчтай хамтран ажиллахыг зөвлөх багийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Зөвлөх багийн гишүүдтэй гэрээ байгуулан, сар бүр барилгын техникийн хяналтын зардлаас санхүүжүүлэн цалинжуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал нар зөвшөөрсүгэй.


4. Зөвлөх багийг өдөр тутамд удирдлага арга зүйгээр ханган ажиллаж, ажлыг сар бүр дүгнэхийг Засаг даргын орлогч Т.Жаргалсайханд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



Zax A/803 Ch
02 4015

Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар
сарын 17-ны өдрийн А/803 дугаар
захирамжийн хавсралт



ЗӨВЛӨХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч:

- Архитектор

Гишүүд :

- Дулааны инженер

- Цэвэр, бохир усны инженер

- Барилгын инженер

- Барилгын төсөвчин

-oOo-